



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын  
2023 оны 3 дугаар улиралд иргэдээс төрийн байгууллага, албан  
тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тухай тайлан

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын “Журам батлах тухай” 2022 оны А/50 дугаар тушаал, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам” 2022 оны А/230 дугаар тушаал болон бусад холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих шийдвэр гаргуулан, хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж байна.

2023 оны 07 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар нийт 104 өргөдөл, гомдол ирүүлснээс 94 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, шийдвэрлэлт 90,4 хувьтай байна. Шийдвэрлэхээр хүлээгдэж байгаа 10 өргөдөл (хугацаа болоогүй) байна.

*Хүснэгт 1. 2023 он 3 дугаар улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал*

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт /хувиар/
			Шийдвэрлэж хариу өгсөн тоо	Бусад байгууллагад шилжүүлсэн тоо	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн тоо		
1	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	104	94	-	-	10	90,4%

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг нийт 5 сувгаар хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн, шийдвэрлүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлж байна.

1. Иргэдээс – 74 /71,2%/;
2. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв – 30 /28,8%/ тус тус хүлээн авсан.

*Хүснэгт 2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/*

Д/д	Газар, хэлтсийн нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Хүлээн авсан байдал					
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	1111 төвөөр	Бусад
1	Захиргаа, удирдлагын газар	57	57				-	
2	Чанарын хяналтын газар	7	1				6	
3	Эм хангамжийн газар	19	-				19	
4	Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар	-	-				-	
5	Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар	9	5				4	
6	Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн газар	3	3				-	
7	Эмийн бүртгэлийн хэлтэс	9	8				1	
8	Эм үйлдвэрлэлийн хэлтэс	-	-				-	
9	Эм шинжлэх лаборатори	-	-				-	
	<b>Нийт</b>	<b>104</b>	<b>74</b>				<b>30</b>	

*Хүснэгт 3. Өргөдөл, гомдлын агуулга*

Д/д	Утга	Өргөдөл, гомдлын нийт тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1	Эм, тарианы хүртээмж, тасалдал, эмийн үнийн өсөлтийн тухай	15	14,5%
2	Эмийн сан, эмийн чанар, эмийн бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийлгэх тухай	8	7,7%
3	Эм оруулж ирэх тухай	4	3,8%
4	Бусад	77	74%
	<b>Нийт</b>	<b>104</b>	<b>100%</b>

*Хүснэгт 4. Өргөдөл, гомдлын төрөл*

Д/д	Төрөл	Бодит тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1	Гомдол	22	21,2%
2	Санал	3	2,8%
3	Хүсэлт	79	76%
	<b>Нийт</b>	<b>104</b>	<b>100%</b>